



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар A/953

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2018 оны “Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын Б.11, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Дундговь аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээний 1.2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны MNS 5633:2019 стандарт”-д хэрэгжилтийн үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Болор-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүдэд: Ц.Ганзориг (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

Б.Саруулцэцэг (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)

Н.Мөнгөнцэцэг (Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)

Л.Дорждэрэм (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн)

А.Цэвээнсүрэн (Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Дэнсмаа (Стандарт хэмжилзүйн хэлтсийн Чанарын шинжээч)

2. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийн үнэлгээг чанартай зохион байгуулж, 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг (М.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4822100831